



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдэлээр анхны өртгөө нөхсөн 130,000,000.00 (нэг зуун гучин сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн, Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга А.Оюун-Эрдэнэ, Архангай аймгийн Чулуут сумын Тамгын газрын дарга Ц.Мөнхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хавсралтад дурдсан хөрөнгийг засаж сэлбэн, орон нутгийн өмчит хуулийн этгээд (Архангай аймгийн Чулуут сумын Тамгын газар) -д ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож, эзэмшүүлэх, ашиглуулах, данс бүртгэлд тусгах, ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

132001309

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 2 дүгээр сарын 11 ны өдрийн
118 дугаар тогтоолын хавсралт



**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
ДАНСНААС ХАСАХ АВТОМАШИН**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн (ашиглалтад) орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл
				(төгрөг)
1	Шевролет Тахое 4175 УБҮ, суудлын арал- IGNSRBE0208187288	2012/2012	181100	130,000,000.00
Нийт дүн				130,000,000.00
				(нэг зуун гучин сая)